

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССИЙН ТОГТООЛ

2026-04-30

Дугаар 01

Улиастай хот

Тооллогын дүнгийн тухай тогтоох нь

Компанийн гүйцэтгэх удирдлагаас 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах, Компанийн 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус аудитийн дүгнэлтийг батлах, Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ болон Гүйцэтгэх удирдлага /ГУ/-ын төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг батлах асуудлуудаар санал хураалтын дүнг гаргав. Санал хураалтад нийт 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/ хувьцаатай 3 /гурав/ хүн оролцлоо, Хүчинтэй саналын хуудас 3 /гурав/ Санал хураалтын дүнг танилцуулахад:

- Компаний ГУ-аас 2024 онд хийсэн ажлын тайлан, 2025 онд хийх ажлын тухай – 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/ санал.
- Компаний 2024 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитийн дүгнэлт – 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/
- ТУЗ болон ГУ-ынтөсвийг батлах - 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/ санал.
- Ногдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах – 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/
- ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох- 52,335 /тавин хоёр мянга гурван зуун гучин тав/ санал.

Тооллогын комиссийн дарга



Гишүүд:

Л.Аззаяа

Д.Нарантуяа

Ц.Оюунчимэг

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2026-04-30

Дугаар 02

Улиастай хот


АЖЛЫН ТАЙЛАН БОЛОН ХИЙХ АЖЛЫН ТУХАЙ

Компаний ТУЗ-өөс хэлэлцүүлсэн 2025 оны ажлын тайлан, Санхүүгийн тайлан зэрэг мэдээллүүдийг сонсоод компаний бүх гишүүдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Завханбаялаг” ХК-аас 2025 онд хийсэн ажлын тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитийн дүгнэлтийг баталсугай
3. 2026 онд компаний борлуулалт, маркетингийн болон санхүү, техник технологийн салбарт ахиц өөрчлөлт гаргаж, бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хэмжээг нэмэгдүүлж, Улаанбаатар хот болон бусад аймгуудын зах зээлд гарах талаар тодорхой ажил хэрэгжүүлэн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, Чацаргана жимсний суулгац тариалах, хөрөнгийн эргэцийг түргэтгэх зэрэг асуудалд онцгой анхаарч ажиллахыг “Завханбаялаг” ХК-ийн ТУЗ-д даалгасугай.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

..........Ю.Бат-Эрдэнэ

..........Ю.Болор-Эрдэнэ

..........Я.Өлзийбүрэн

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026-04-30

Дугаар 03


Улиастай хот

ЗАРДАЛ БАТЛАХ ТУХАЙ

Компаний бүх гишүүдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Завханбаялаг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлыг 27,000,000 /Хорин долоон сая/ төгрөгөөр, Гүйцэтгэх удирдлагын зардлыг 28,000,000 /Хорин найман сая/ төгрөгөөр
2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулж түүнд тавих хяналтаа сайжруулж ажиллахыг Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

..........Ю.Бат-Эрдэнэ
..........Ю.Болор-Эрдэнэ
..........Я.Өлзийбүрэн

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2026-04-30

Дугаар 04

Улиастай хот


2025 оны ногдол ашиг хуваарилалтын тухай


Компаний ерөнхий санхүүчээс хийсэн мэдээлэл 2025 оны санхүүгийн тайлан балансийн дүн, санхүүгийн үр дүнгийн талаар хийсэн мэдээлэл тооцооллыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. 2025 оны аж ахуй, үйл ажиллагааны үр дүнд 16,800,000 /Арван зургаан сая найман зуун мянга/ төгрөгийн ашиг олсон дүн гарсан ба түүнийг хуваарилах нь ач холбогдол багатай ба компаний техник, технологийн шинэчлэл хийхэд зарцуулах шаардлага байгаа тул 2025 оны санхүүгийн үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ашиг орлого хуваарилах боломжгүй гэж үзсүгэй.
2. Санхүүгийн нөөц боломжийг ашиглан 2026 онд техник, технологийг шинэчлэх чиглэлээр хийх ажилд оруулах хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төслийг гаргаж ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ю.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

.......... Ю.Бат-Эрдэнэ



.......... Ю.Болор-Эрдэнэ

.......... Я.Өлзийбүрэн

“Завханбаялаг” ХК-ийн нийт 56,338 /Тавин зургаан мянга гурван зуун гучин найм/ ширхэг хувьцаанаас нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хувьцаа /2026 оны 04-р сарын 30-ны байдлаар/

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь
Я.Өлзийбүрэн	22,167	39%
Ю.Бат-Эрдэнэ	20,112	36%
Ю.Болор-Эрдэнэ	10,056	18%
	52,335	93%

“Завханбаялаг” ХК хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн хурлын ирцийн бүртгэл

№	Нэрс	Хувьцааны тоо	Гарын үсэг
1.	Я.Өлзийбүрэн	22,167	
2.	Ю.Бат-Эрдэнэ	20,112	
3.	Ю.Болор-Эрдэнэ	10,056	

Хурал зохион байгуулах комисс

**"ЗАВХАНБАЯЛАГ" ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЗЛЖИТ
ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/ 10р овогтой Завханбаялаг

Регистрийн дугаар U282082708

Гэрийн хаяг Ув.х.д. Хам. д. 5-хүрэл, 11 хороо, Хөтөлбөмт хойхон В8

Эзэмшиж буй хувьцааны тоо 10,056

Төлөөлж байгаа бол хэнийг эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар
Төлөөлж буй хүний нэр регистер

Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.Компаний ТУЗ-өөс 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлыг батлах.	10,056		
2 Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлт.	10,056		
3.ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах.	10,056		
4.Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах	10,056		
5.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгох.			
ТУЗ-ЫН ГИШҮҮНД			
1.Я.Өлзийбүрэн.	10,056		
2. Я.Ганбаатар	10,056		
3.Г.Түвшинбат.	10,056		
4. Ю.Бат-Эрдэнэ.	10,056		
5.М.Алтанцэцэг.	10,056		
6. Т. Мөнхбаатар.	10,056		
ТУЗ-ЫН ХАРАА БУС ГИШҮҮНД			
7. Ц.Чанцаа.	10,056		
8. Я.Хишигдэлгэр	10,056		
9. П.Баянмөнх.	10,056		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг Завханбаялаг /10.20.20-дугаар/

Санал авах хуудсыг хүчингүйдтооцсон бол шалтгаан Хүчингүйд

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга Л.Аззаяа

Гишүүн Д.Нарантуяа

Ц.Оюунчимэг



**"ЗАВХАНБАЯЛАГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/ Адамсүрэн овогтой Оюундүрж
Регистрийн дугаар 11754052867
Гэрийн хаяг Завхан сум сумуудын захиралын газар
Эзэмшиж буй хувьцааны тоо 22167

Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар
Төлөөлж буй хүний нэр регистер

Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.Компаний ТУЗ-өөс 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлыг батлах.	22167		
2 Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлт.	22167		
3.ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах.	22167		
4.Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах	22167		
5.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгох.			
ТУЗ-ЫН ГИШҮҮНД	22167		
1.Я.Өлзийбүрэн.	22167		
2. Я.Ганбаатар	22167		
3.Г.Түвшинбат.	22167		
4. Ю.Бат-Эрдэнэ.	22167		
5.М.Алтанцэцэг.	22167		
6.Т. Мөнхбаатар.	22167		
ТУЗ-ЫН ХАРАА БУС ГИШҮҮНД			
7. Ц.Чанцаа.	22167		
8. Я.Хишигдэлгэр	22167		
9. П.Баянмөнх.	22167		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг Оюундүрж
Санал авах хуудсыг хүчингүйдтооцсон бол шалтгаан Хүчингүй
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон
Тооллогын комиссын дарга Л.Азжаяа
Гишүүн Д.Нарантуяа
Ц.Оюунчимэг



**"ЗАВХАНБАЯЛАГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/ ЮраРегистрийн дугаар 21272092714Гэрийн хаяг Ув хот БЗР-26 р хорооЭзэмшиж буй хувьцааны тоо 20112

Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар

Төлөөлж буй хүний нэр регистер

Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.Компаний ТУЗ-өөс 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлыг батлах.	20112		
2 Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлт.	20112		
3.ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах.	20112		
4.Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах	20112		
5.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгох.			
ТУЗ-ЫН ГИШҮҮНД			
1.Я.Өлзийбүрэн.	20112		
2. Я.Ганбаатар	20112		
3.Г.Түвшинбат.	20112		
4. Ю.Бат-Эрдэнэ.	20112		
5.М.Алтанцэцэг.	20112		
6.Т. Мөнхбаатар.	20112		
ТУЗ-ЫН ХАРАА БУС ГИШҮҮНД			
7. Ц.Чанцаа.	20112		
8. Я.Хишигдэлгэр	20112		
9. П.Баянмөнх.	20112		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Санал авах хуудсыг хүчингүйдтооцсон бол шалтгаан

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга

Гишүүн

/Л.Азаяа/

/Д.Нарантуяа/

/Ц.Оюунчимэг/

**“ЗАВХАНБАЯЛАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2025 оны ээлжит 1-р хуралдааны тэмдэглэл**

2026-04-30

14.00 цаг

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн 14.00 цагт танхимаар эхэллээ.

Хуралд: Тус компаний хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигч болох Я.Өлзийбүрэн, Ю.Бат-Эрдэнэ, Ю.Болор-Эрдэнэ нар оролцлоо.

Мөн санал өгөх эрхгүйгээр Дэд захирал М.Алтанцэцэг, Нябо Л.Лхамжав, ТУЗын гишүүд болох Т.Мөнхбаатар, Я.Хишигдэлгэр, Я.Ганбаатар нар байлцав.

Ю.Бат-Эрдэнэ хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдан явууллаа.

Хурлын дарга Ю.Бат-Эрдэнэ: Хурал зохион байгуулах комиссоос хурлын ирц танилцуулна уу.

Хурал зохион байгуулах комиссийн дарга Ариунзаяа: Нийт хувьцаа эзэмшигчээс хуралд оролцохоор ирсэн 3 хувьцаа эзэмшигч байна. Компанийн гаргасан нийт 56,338 ширхэг хувьцааны 52,335 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 93%-ийг эзэмшигч гишүүд ирсэн тул хурлыг эхлүүлье.

Хурлын дарга Ю.Бат-Эрдэнэ хурлыг удирдан явуулж дотоод журам, дэг, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр батлуулав. Үүнд:

- КомпанийГУ-аас 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлын тухай
 - Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитийн дүгнэлт
 - ТУЗ болон ГУ-ын төсвийг батлах
 - Ногдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах
 - ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох
1. “Завханбаялаг” ХК-ний 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 онд хийх ажлын төлөвлөгөөг дэд захирал/үйл ажиллагааны тайлан/, ерөнхий технологич /үйлдвэрлэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт/ нар уншиж танилцуулав

2. 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитийн дүгнэлтийг ерөнхий санхүүч/Л.Лхамжав/ танилцуулав
3. Асуудлуудыг хамтад нь шийдэхийн тулд хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулав.
Хэлэлцсэн асуудлаар гишүүд болон хуралд оролцогчод санал шүүмжлэл гаргав.

Хувьцаа эзэмшигч Я.Өлзийбүрэн:

Хурлаар оруулж хэлэлцүүлж байгаа мэдээлэл, тогтоолын төслүүдтэй танилцлаа. Хөрөнгийн зах зээл монгол оронд ид хөгжиж байгаа учир Хувьцаат компанийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх саналыг дэмжиж байна. Харин тусгай даалгаварыг ТУЗ-өөс боловсруулж гүйцэтгэх удирдлагад хүргүүлэх нь зүйтэй. Хийх анхаарах зүйл их байгаа. Ялангуяа энэ жил отгонтэнгэр хайрханы тахилга болж буйтай холбогдуулан хөл хөдөлгөөн ихтэй болох учир борлуулалт нэмэгдүүлэх зорилгоор хэдэн хэдэн цэгүүдэд повилон, асар , гэр барьж худалдаа хийх хэрэгтэйг онцлов

Хувьцаа эзэмшигч Ю.Бат-Эрдэнэ:

Борлуулалт маркетингийн тал дээр тодорхой хэмжээнд анхаарах хэрэгтэй байна. Энэ талын хөрөнгө мөнгийг шийдвэрлэж өгөхийг хүсье. ТУЗ-д боловсруулж байгаа төсөл төлөвлөгөөгөө танилцуулж хөрөнгө мөнгөний асуудлуудыг шийдвэрлүүлье Энэхүү хуралд компаний удирдагууд оролцож байгаа тул хурлын шийдвэр ба хуралд яригдсан асуудлыг хэрэгжүүлэх талаар сайн ажиллах хэрэгтэй. Бид анхаарах асуудлын талаар тусгайлан хэлэх болно. Гүйцэтгэх удирдлагынажил тодорхой үр дүн гаргасан байна. Мөн анхаарах асуудлууд ч байна. Дэлгүүр ба үйлдвэрийн өнгө үзэмжийг сайжруулах талаар анхаармаар байна. Цаг үеийг дагаж өөрчлөгдөж хөгжиж байхад бид хоцрох ёсгүй манлайлж ажиллах хэрэгтэй.

Хурлын дарга Ю.Бат-Эрдэнэ:

Өөр санал хэлэх гишүүд байна уу?

Хувьцаа эзэмшигч Ю.Болор-Эрдэнэ:

Борлуулалт маркетингийн талаар интернет орчинд сайн ажиллах хэрэгтэй байгаа нь анзаарагдаж байна. Энэ тал дээр анхаарч ажиллаарай та бүхэнд ажлын амжилт хүсье.

Ю.Бат-Эрдэнэ: Заа өөр саналгүй бол 5-р асуудал болох ТУЗ-ын гишүүдэд нэр дэвшигчидийг танилцуулж санал хураалтандаа ороё.

Санал хураалт дуусч хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулан хурлыг хааж үг хэлэв.

Танилцсан: хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид :

Ю.Бат-Эрдэнэ.

Ю.Болор-Эрдэнэ.

Я.Өлзийбүрэн.

Бат-Эрдэнэ

Болор-Эрдэнэ

Өлзийбүрэн